



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Г “Монгол секьюритиес” ХК-ийн 7
андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.9, 8.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол секьюритиес” ХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2011 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, “Монгол секьюритиес” ХК-ийн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН